



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/245-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БУГ	Боловсрол урлагийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ТУЛГА ТАНАА

2024.02.25 № САА-2024/245-НЭ-СНА-ТНЗ
танай _____-ны № _____-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд БШУГ-аас 11,416.9 мянган төгрөгийн ном, 15,686.2 мянган төгрөгийн өртөг бүхий физик, технологийн кабинетын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 53,663.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	236,729,731.65	521,648,628.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	132,300,920.60	394,501,828.57
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	132,300,920.60	394,501,828.57
31210	Төгрөг	132,300,920.60	394,501,828.57
31211	Төрийн сангийн харилцах	132,300,920.60	394,501,828.57
35	БАРАА МАТЕРИАЛ	104,428,811.05	127,146,800.39
35100	Түүхий эд материал	43,220,099.20	55,637,068.54
35110	Тусгай зориулалттай материал	43,220,099.20	55,637,068.54
35400	Хангамжийн материал	61,208,711.85	71,509,731.85
35470	Бусад хангамжийн материал	61,208,711.85	71,509,731.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,418,022,837.99	1,474,548,292.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,418,022,837.99	1,474,548,292.88
39200	Биет хөрөнгө	1,093,261,587.89	1,150,268,709.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	867,950,789.54	867,950,789.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	-125,327,812.69	-158,182,130.65
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	260,068,312.20	352,382,967.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71,701,166.14	-63,423,443.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,892,315.03	103,564,134.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,168,747.19	-46,068,919.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,412,967.32	55,412,967.32
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,237,879.53	-20,715,459.33
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	74,372,809.35	59,347,804.85
39300	Биет бус хөрөнгө	324,761,250.10	324,279,583.20
39301	Программ хангамж	1,705,000.00	1,705,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-943,749.90	-1,425,416.80
39303	Бусад биет бус хөрөнгө	324,000,000.00	324,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,654,752,569.64	1,996,196,921.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,654,752,569.64	1,996,196,921.84
51	Засгийн газрын хувь оролцоо	1,654,752,569.64	1,996,196,921.84
51100	Засгийн газрын оруулсан капитал	869,619,679.63	869,619,679.63
51200	Хуримтлагдсан үр дүн	87,192,224.79	428,636,576.99
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,567,560,344.85	87,192,224.79
51220	Тайлант үеийн үр дүн	1,654,752,569.64	341,444,352.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	697,940,665.22	697,940,665.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,654,752,569.64	1,996,196,921.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,882,978,794.52	3,013,773,596.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,526,544,331.79	92,687,011.84
120	Нийтлэг татварын бус орлого	1,526,544,331.79	92,687,011.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,990,330.00	6,266,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,285,400.00	6,266,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,704,930.00	0.00
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	0.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,367,009,340.74	59,317,822.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	108,544,661.05	27,103,189.34
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,356,434,462.73	2,921,086,585.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,199,582,300.00	2,804,573,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,199,582,300.00	2,804,573,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,900,000.00	6,023,858.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,900,000.00	6,023,858.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	146,952,162.73	110,489,327.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	146,952,162.73	110,489,327.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,228,226,224.88	2,652,902,197.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,228,226,224.88	2,652,902,197.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,017,355,824.88	2,455,622,287.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,540,428,428.06	1,896,079,801.11
210101	Үндсэн цалин	1,030,209,311.85	1,270,836,743.11
210102	Нэмэгдэл	420,218,502.21	540,398,110.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	90,000,614.00	84,844,948.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,294,110.95	243,432,978.25
210201	Тэтгэврийн даатгал	132,639,536.26	166,826,582.98
210202	Тэтгэмжийн даатгал	15,505,538.88	19,633,102.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,360,570.92	15,565,421.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,980,688.18	3,755,860.05
210205	Эрүүл мэндийн даатгал	29,807,776.71	37,652,011.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,664,347.88	80,165,317.00
210301	Гэрэл, цахилгаан	9,664,592.78	11,915,994.79
210302	Түлш, халаалт	43,639,936.10	59,881,601.21
210303	Цэвэр, бохир ус	7,359,819.00	8,367,721.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,445,600.00	19,220,010.00
210604	Урсгал засвар	40,445,600.00	19,220,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,063,300.00	22,399,400.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,400,000.00	5,374,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,663,300.00	17,024,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,460,037.99	194,324,781.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,625,165.24	71,096,712.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,671,300.00	26,682,448.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,163,572.75	96,545,620.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,870,400.00	197,279,910.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	210,870,400.00	197,279,910.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	174,992,600.00	160,798,510.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,877,800.00	36,481,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,654,752,569.64	360,871,399.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	19,427,047.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	19,427,047.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,654,752,569.64	341,444,352.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	/төгрөгөөр/ ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,363,719,862.73	2,927,352,585.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,285,400.00	6,266,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,285,400.00	6,266,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,285,400.00	6,266,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,285,400.00	6,266,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,356,434,462.73	2,921,086,585.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,199,582,300.00	2,804,573,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,199,582,300.00	2,804,573,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,900,000.00	6,023,858.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,900,000.00	6,023,858.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	146,952,162.73	110,489,327.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	146,952,162.73	110,489,327.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,121,946,802.13	2,551,971,377.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,121,946,802.13	2,551,971,377.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,914,197,852.13	2,354,295,467.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,540,428,428.06	1,896,079,801.11
210101	Үндсэн цалин	1,030,209,311.85	1,270,836,743.11
210102	Нэмэгдэл	420,218,502.21	540,398,110.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	90,000,614.00	84,844,948.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,294,110.95	243,432,978.25
210201	Тэтгэврийн даатгал	132,639,536.26	166,826,582.98
210202	Тэтгэмжийн даатгал	15,505,538.88	19,633,102.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,360,570.92	15,565,421.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,980,688.18	3,755,860.05
210205	Эрүүл мэндийн даатгал	29,807,776.71	37,652,011.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,664,347.88	80,165,317.00
210301	Гэрэл, цахилгаан	9,664,592.78	11,915,994.79
210302	Түлш, халаалт	43,639,936.10	59,881,601.21
210303	Цэвэр, бохир ус	7,359,819.00	8,367,721.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,445,600.00	18,824,010.00
210604	Урсгал засвар	40,445,600.00	18,824,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,063,300.00	22,399,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,400,000.00	5,374,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,663,300.00	17,024,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,302,065.24	93,393,960.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,703,765.24	66,411,512.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,598,300.00	26,982,448.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,748,950.00	197,675,910.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,748,950.00	197,675,910.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	171,871,150.00	161,194,510.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,877,800.00	36,481,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	241,773,060.60	375,381,207.97
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	109,472,140.00	113,180,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,472,140.00	113,180,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	109,472,140.00	113,180,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	109,472,140.00	113,180,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-109,472,140.00	-113,180,300.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	132,300,920.60	262,200,907.97
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	132,300,920.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,300,920.60	394,501,828.57

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	869,619,679.63	697,940,665.22	87,192,224.79	1,654,752,569.64
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	869,619,679.63	697,940,665.22	87,192,224.79	1,654,752,569.64
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	341,444,352.20	341,444,352.20
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,619,679.63	697,940,665.22	428,636,576.99	1,996,196,921.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,059,653,505.6	2,665,151,677.0	394,501,828.6	87.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,946,473,205.6	2,551,971,377.0	394,501,828.6	86.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,710,850,705.6	2,354,295,467.0	356,555,238.6	86.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,212,422,800.0	1,896,079,801.1	316,342,998.9	85.7
210101	Үндсэн цалин	1,478,886,700.0	1,270,836,743.1	208,049,956.9	85.9
210102	Нэмэгдэл	629,157,300.0	540,398,110.0	88,759,190.0	85.9
210104	Урамшуулал	104,378,800.0	84,844,948.0	19,533,852.0	81.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,552,200.0	243,432,978.3	33,119,221.8	88.0
210201	Тэтгэврийн даатгал	188,055,200.0	166,826,583.0	21,228,617.0	88.7
210202	Тэтгэмжийн даатгал	22,124,300.0	19,633,102.3	2,491,197.7	88.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,699,400.0	15,565,421.9	2,133,978.2	87.9
210204	Ажилгүйдлийн даатгал	4,424,900.0	3,755,860.1	669,040.0	84.9
210205	Эрүүл мэндийн даатгал	44,248,400.0	37,652,011.0	6,596,389.0	85.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,165,317.0	80,165,317.0	0.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	11,915,994.8	11,915,994.8	0.0	100.0
210302	Түлш, халаалт	59,881,601.2	59,881,601.2	0.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	8,367,721.0	8,367,721.0	0.0	100.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,824,010.0	18,824,010.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	18,824,010.0	18,824,010.0	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,639,378.6	22,399,400.0	4,239,978.6	84.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,751,478.6	5,374,900.0	3,376,578.6	61.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,887,900.0	17,024,500.0	863,400.0	95.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,247,000.0	93,393,960.7	2,853,039.3	97.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,264,500.0	66,411,512.7	2,852,987.3	95.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,982,500.0	26,982,448.0	52.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	235,622,500.0	197,675,910.0	37,946,590.0	83.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	235,622,500.0	197,675,910.0	37,946,590.0	83.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	200,741,100.0	161,194,510.0	39,546,590.0	80.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,881,400.0	36,481,400.0	-1,600,000.0	104.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	113,180,300.0	113,180,300.0	0.0	100.0
	Дотоод эх үүсвэрээр	113,180,300.0	113,180,300.0	0.0	100.0
222001	Тоног төхөөрөмж	112,112,300.0	112,112,300.0	0.0	100.0
223001	Бусад хөрөнгө	1,068,000.0	1,068,000.0	0.0	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,059,653,505.6	3,059,653,505.6	0.0	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,949,164,178.6	2,949,164,178.6	0.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,804,573,400.0	2,804,573,400.0	0.0	100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,600,000.0	1,600,000.0	0.0	100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,600,000.0	1,600,000.0	0.0	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	110,489,327.0	110,489,327.0	0.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	110,489,327.0	110,489,327.0	0.0	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,689,858.0	10,689,858.0	0.0	100.0
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,689,858.0	10,689,858.0	0.0	100.0
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132,300,920.6	132,300,920.6	-	100.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,300,920.6	394,501,828.6	262,200,908.0	298.2
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	98	98		100.0
6	Удирдах ажилтан	1	1		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	78	78		100.0
8	Үйлчлэх ажилтан	19	19		100.0
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,735.	1,601		92.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь “Хүүхэд бүр суралцах тэгш боломжийг бүрдүүлэн, суралцахуйд суурилсан арга зүйг хамтран хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Тус байгууллага нь дараах чиг үүрэгтэй ажилласан байна. Үүнд:

- Сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах,
- Сурагчдын хөгжил, төлөвшлийг хангах,
- Сургалтын үйл ажиллагаа, багшийн ажлын гүйцэтгэлд суурилан багшийн тасралтгүй хөгжлийг хангах,
- Сургуульд суурилсан менежментийг сайжруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
 1. *"ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",*
 2. *"Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 341,444.4 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	132,300.9	394,501.8	262,200.9
Авллага			
Бараа материал	104,428.8	127,146.8	22,718.0
Үндсэн хөрөнгө	1,418,022.8	1,474,548.3	56,525.5
Нийт хөрөнгө	1,654,752.6	1,996,196.9	341,444.4
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,654,752.6	1,996,196.9	341,444.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,654,752.6	1,996,196.9	341,444.4

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 394,501.8 мянган төгрөг болж 262,200.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 127,146.8 мянган төгрөг болж 22,718.0 мянган төгрөгөөр өссөн нь БШУГ-аас 11,416.9 мянган төгрөгийн ном, 15,686.2 мянган төгрөгийн физик, технологийн кабинетын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 226,312.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж 230,697.6 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,474,548.3 мянган төгрөг болж 56,525.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 113,180.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БШУГ-аас 59,317.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ширээ сандлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолоор 77,536.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 38,436.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 3,263,862.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 90,192.5 мянган төгрөг, нийт 3,354,055.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 1,222,546.8 мянган төгрөгөөр буюу цалин хөлсийг 747,348.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 21,429.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,099.8 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 468,217.8 мянган төгрөгөөр бууруулж, урсгал засварын зардлыг 7,892.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 8,655.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 2,131,508.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин, НДШ-ийн зардлыг 695,700.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 11,402.4 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 22,431.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 7,202.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад

зардлыг 119,070.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 72,338.5 мянган төгрөгөөр нийт 928,145.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Ингэснээр улсын төсвөөс 2,804,573.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 110,489.3 мянган төгрөгийн санхүүжилт, дээд шатны төсөв захирагчаас 1,600.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,689.8 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 132,300.9 мянган төгрөг төвлөрүүлэхээр, төсвийг нийт 3,059,653.5 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 3,059,653.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,665,151.7 мянган төгрөгийг зарцуулж, 394,501.8 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,665,151.7 мянган төгрөг буюу 87.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 354,955.2 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 39,546.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	7,155.1	7,155.1	-	100.0
		2	80312- Сургалт семинар	5,924.7	5,924.2	0.5	100.0
		3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,700.0	1,600.0	100.0	94.1
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	11,144.5	10,623.5	521.0	95.3
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	200,741.1	161,194.5	39,546.6	80.3
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	82,929.1	82,929.1	-	100.0
		7	81823- Боловсролын багшийн сургалт	21,408.1	19,076.6	2,331.5	89.1
		8	81834- Боловсролын стандарт сургалт	2,342,948.6	2,008,344.1	334,604.6	85.6
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	261,661.3	248,016.5	13,644.8	94.8
		11	81848-сурах бичгийн түрээс	9,127.7	5,374.9	3,752.8	58.9
		12	83603- Дээд шатны төсвөөс	4,423.9	4,423.8	0.1	100.0
		13	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	110,489.3	110,489.3	-	100.0
		Нийт				3,059,653.5	2,665,151.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан боловч бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Мөнх Би То Са” ХХК, “Уужим хараа” ХХК, “Чавхдаст хүлэг” ХХК-иудтай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,228,226.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 22,282.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 164,984.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй учраас “Мөнх Би То Са” ХХК, “Уужим хараа” ХХК, “Хараа мөнгилмаа” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 214 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн

бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх 2,074.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргаснаас албан шаардлага, шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчлийг дахин гаргахгүй ажиллах зөвлөмж өгсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5		5		100.0
Албан шаардлага	1	2,074.3	1	2,074.3	100.0
Нийт дүн	6	2,074.3	6	2,074.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу **1,564.4** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.Үүнд:

- Нягтлан бодогч Г.Болорцэцэгт 875.3 мянган төгрөг,
- Нярав Э.Болор Эрдэнэд 689.1 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж,

баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

Аудитаар нийт **5,912.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **393.0** мянган төгрөгийн албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **5,519.2** мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Үдийн хоолны зардлаас бараа үйлчилгээний зардалд 393.0 мянган төгрөгийг хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: 1. Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр буюу “*Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас*”-гүйгээр үйлчилгээний албан хаагчдад 5,519.2 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1 дэх “*Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, 7 хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Үйлчилгээний нэмэгдэл хөлс баталгаажуулалгүй	албан олгох хуудсаар	1	5,519.2										
3. Зардлыг хөтөлбөр зарцуулсан	хооронд нь гүйлгэн	1	393.0			1	393.0						
Дүн		2	5,912.2			1	393.0			1	5,519.2		

/мянган төгрөгөөр/

Үүнээс